

*М. Сэлэнгэ (ХАА)*  
*Аудитыг зөвчлөх өргөтгөл*  
*СЭ-нд оруулах.*  
*Төлвийг нь харах*  
*Төвдөөлөх*  
*У.Г.С*

БАТЛАВ.  
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*[Signature]*  
О. ТЭНГИС

ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ  
АЖЛЫН ДААЛГАВАР

2020 оны 04 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар УАН-2020/27А

Улаанбаатар хот

### ЗОРИЛГО:

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2018-2019 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд хийх гүйцэтгэлийн аудитын хүрээнд тус компанийн үйл ажиллагааны үр дүн, эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын хэрэгжилтийн үр нөлөө, хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд шинжээчийн дүгнэлт гаргахад энэхүү ажлын зорилго оршино.

### 1. ҮНДЭСЛЭЛ:

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 04 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2018-2019 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлт сэдэвт гүйцэтгэлийн аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шинжээчийг зохих журмын дагуу томилон ажиллуулж болно” гэж заасны дагуу санхүү, төсвийн асуудал, гүйцэтгэлийн аудитаар мэргэшсэн, ажлын туршлага бүхий зөвлөхийг аудитад татан оролцуулах шаардлагатай байна.

### 2. ЗОРИЛТ:

Шинжээч нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2018-2019 оны үйл ажиллагаа үр дүнтэй байгаа эсэх, Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого үр нөлөөтэй хэрэгжсэн эсэх, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулсан эсэх талаар дүгнэлт гаргаж, холбогдох зөвлөмж боловсруулна.

### 3. ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ АЖИЛБАРУУД:

Шинжээч нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2018-2019 оны үйл ажиллагаа үр дүнтэй байгаа эсэх, Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого үр нөлөөтэй хэрэгжсэн эсэх, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулсан эсэхэд дүгнэлт гаргах ажлыг дараах дэд зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

## Төлөвлөлтийн үе шат:

- 3.1. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хууль болон бусад эрх зүйн баримт бичгийн судалж эрх зүйн тогтолцооны зураглалыг гаргах,
- 3.2. Тавантолгойн орд газрын техник, эдийн засгийн үндэслэл, хувьцаат компанийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны тайлан, аудитлагдсан санхүүгийн тайлан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, борлуулалтын гэрээ, орлого, зарлагын байдалд дүн шинжилгээ хийж, аудитын эрсдэлийг тодорхойлон, асуудлын шинжилгээг боловсруулна.

## Гүйцэтгэлийн үе шат:

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2018-2019 оны үйл ажиллагааны үр дүнгийн хүрээнд:

- 3.3. Компанийн үйл ажиллагаанд ил тод, хариуцлагатай байх, хууль дээдлэх, үр ашиг болон үр нөлөөтэй байх зэрэг компанийн сайн засаглалын зарчим мөрдөгдөж байгаа эсэхэд дүгнэлт гаргах,
- 3.4. Бүтээгдэхүүн борлуулах гэрээ болон бүтээгдэхүүний үнэ, олборлосон болон борлуулсан бүтээгдэхүүний хэмжээг бодиттой тогтоож байгаа эсэх, борлуулалтын орлогын бүртгэл үнэн зөв тайлагнагдсан эсэхэд дүгнэлт гаргах,
- 3.5. Үндсэн үйл ажиллагааны урсгал болон хөрөнгийн зардлыг үр ашигтай төлөвлөх тогтолцоо бүрдсэн эсэх, хөрөнгийн зарцуулалт хэрэгцээ, шаардлагыг хангасан үр нөлөөтэй байгаа эсэхэд дүгнэлт гаргах,
- 3.6. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт холбогдох хууль, эрх зүйн хүрээнд үр ашигтай явагдсан эсэхэд дүгнэлт гаргах,
- 3.7. Компаниас санхүүжүүлж байгаа төмөр зам, дэд бүтцийн төслүүдэд олгосон санхүүжилт үр нөлөөтэй байгаа эсэхэд дүгнэлт гаргах,
- 3.8. Охин компаниудын үйл ажиллагаа үр дүнтэй байгаа эсэхэд дүгнэлт гаргах.

Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын хэрэгжилт үр нөлөөтэй байгаа эсэхэд:

- 3.9. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын зарчим, зорилтод нийцүүлсэн хууль, эрх зүйн тогтолцоог бүрдүүлсэн эсэхэд дүгнэлт гаргах;
- 3.10. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх сайн засаглалын тогтолцоог бүрдүүлсэн эсэхэд дүгнэлт гаргах;
- 3.11. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх санхүүгийн болон эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн эсэхэд дүгнэлт гаргах;
- 3.12. Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын 3.3, 3.5, 3.6, 3.7-д заасан зорилтыг хангасан эсэх болон 4 дүгээр бүлэгт заасан арга замыг авч хэрэгжүүлсэн эсэхэд дүгнэлт гаргах.

Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулсан эсэхэд:

- 3.13. Ашигт малтмалын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийн биелэлт тухайлбал,
  - Уурхайн талбайн хил тогтоох, шав тэмдэг тавих,
  - Байгаль орчныг хамгаалах,
  - Байгаль орчныг хамгаалах талаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг,
  - Байгаль орчны нөлөөллийн шинэчилсэн үнэлгээ, менежментийн төлөвлөгөөг хянуулах,
  - Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх,
  - Нутгийн захиргааны байгууллагатай харьцах,
  - Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр,
  - Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр,
  - Мэдээ, тайлан гаргах зэрэг хуулийн зохицуулалтын биелэлтийг гаргах.

## **Тайлагналын үе шат:**

- 3.14. Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн шинжээчийн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж нэгтгэл тайланд хүргүүлэх,
- 3.15. Аудитын нэгтгэл тайланг боловсруулахад оролцож, холбогдох үе шатны хяналтыг хийлгэн, баталгаажуулах.

## **4. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ:**

Шинжээч нь Монгол Улсын Засгийн газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2018-2019 үйл ажиллагааг бүрэн хамруулж дүгнэлт гаргана.

## **5. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН:**

Шинжээч нь ажлын даалгаварт тусгагдсан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, гэрээт ажлын хүрээнд хамрагдсан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэхийг хянан үзэж дүгнэлт гаргаж, үр дүнг тусгасан шинжээчийн тайланг бэлтгэнэ.

Шинжээчийн тайланд дүгнэлт гаргах явцад илэрсэн алдаа зөрчил, тэдгээрийг учир шалтгаан болон үр дагавар, эрсдэлд хийсэн дүн шинжилгээний үр дүнгээс гадна цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж, санал боловсруулж тусгана.

Шинжээчийн тайлан болон хавсралтаар гаргасан судалгаа, тооцоолол, бусад нотлох зүйлс, ажлын баримт материалыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

## **6. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:**

Дүгнэлт гаргах ажлыг гэрээгээр гүйцэтгэх шинжээч нь Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын аудитын баг бүрэлдэхүүнтэй хамтарч ажиллаж, шаардлагатай дэмжлэг, туслалцааг тус газраас үзүүлнэ.

Ажлын даалгаварт тусгагдсан ажлын гүйцэтгэгчээр шалгарсан шинжээч нь ажил эхлүүлэх, ажлын явцад үүсэх хүндрэл бэрхшээл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор захиалагч Үндэсний аудитын газар /Гүйцэтгэлийн аудитын газар/-тай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч болно.

Шинжээчийн дүгнэлт гаргах ажлын явцад илэрсэн зөрчил, шийдвэрлэх боломжгүй асуудал үүссэн тохиолдолд тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд шууд мэдэгдэнэ.

## **7. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА:**

Шинжээч нь аудитын төлөвлөлт, талбарын үе шатнаас эхлэн тайлагналын үе шат дуусах хүртэл хугацаанд хариуцсан асуудлаар аудитын багт мэргэжил, арга зүйн туслалцааг үзүүлж хамтран ажиллана.

**Эхлэх хугацаа:** 2020 оны 6 дугаар сарын 15-ны өдөр

**Дуусах хугацаа:** 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдөр

## **8. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:**

Шинжээч нь бодлогын хэрэгжилт, санхүү, төсөв, компанийн засаглалын үр нөлөөг тооцох мэдлэг, боловсролыг эзэмшсэн, аудитын салбарт ажиллаж байсан ажлын дадлага, туршлагатай дүгнэлт гаргах чадвартай байна.

Шинжээч нь дараах шаардлагыг хангасан мэдлэг, ур чадвартай байна. Үүнд:

- Санхүү, эдийн засаг эсвэл төрийн удирдлагын чиглэлээр магистр буюу түүнээс дээш зэрэгтэй;
- Аудитын салбарт 5 буюу түүнээс дээш жил ажилласан туршлагатай;
- Уул уурхайн салбарт хийгдсэн аудитад ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.

Шинжээч нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.

Шинжээч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

## 9. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ:

Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулах хоёр талт гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын үр дүнд захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан санхүүжүүлэгч гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

Гэрээт ажлын санхүүжилтийг гэрээнд заасан төлбөрийн хуваарийн дагуу олгоно.

### Хянасан:

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ОЮУНГЭРЭЛ

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЕНЕЖЕР

Н.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.САРУУЛ

### Боловсруулсан:

АХЛАХ АУДИТОР

Б.БАТДЭЛГЭР